МЭДЭЭ · 2024 оны 9-р сарын 23

ЭМГЭНЭЛ





ЭМГЭНЭЛ

ЛЭГЦЭГИЙН БААСАН
(1944-2024)

Монгол Улсын Гавьяат багш, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, хуульч ЛЭГЦЭГИЙН БААСАН нь өвчний улмаас таалал төгсөж боловсрол, хууль зүйн шинжлэх ухааны салбарт нөхөж баршгүй гарз тохиолоо.

Профессор ЛЭГЦЭГИЙН БААСАН нь 1963-1967 онд МУИС-ийн Нийгмийн ухааны факультетын хуулийн ангийг төгссөн. Тэрээр 1984 онд дэд профессор, 2010 онд профессор, 1995 онд МУИС-ийн Хууль зүйн доктор, 1999 онд Хууль зүйн шинжлэх ухааны докторыг тус тус хамгаалсан.

Л.Баасан нь Монгол Улсын Хууль зүйн болон дээд боловсролын салбарт 1967 оноос хойш тасралтгүй ажиллаж, өнөөдрийг хүртэл хугацаанд өөрийн үнэтэй хувь нэмрээ оруулсан хуульч, гавьяат багш байлаа. Тэрээр 1967-1970 онд Өвөрхангай аймгийн прокурорт чухал хэргийн мөрдөн байцаагч, мөрдөн байцаалт эрхэлсэн туслах прокурор, 1970-1972 онд Говь-Алтай аймгийн прокурорын ерөнхий хяналт эрхэлсэн прокурор, 1984-1990 онд Улсын Дээд Шүүхийн шүүгч, 1972-1984, 1992-1993 онуудад МУИС-д эрх зүйн багш, тэнхимийн эрхлэгч, 1992 онд Улсын бага хурлын дэргэдэх төр, нийгэм судлалын академийн төрийн байгуулалтын тэнхимийн эрхлэгч, 1992-1998 онд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн, 1996 - 2015 он хүртэл Отгонтэнгэр Их Сургуулийн эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал, 2015 оноос өнөөг хүртэл Отгонтэнгэр Их Сургуулийн профессороор ажиллаж байсан юм.

Бидний сэтгэлд "ХӨДӨЛМӨРИЙН ЭРХ ЗҮЙН БААСАН" гэж үүрд дурсах эрхэм багш маань 45 ном сурах бичиг, эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлэл 110 гаруйг бичиж нийтийн хүртээл болгосон эрдэм номын их хүмүүн байлаа.

Эрдэмтэн профессор Л.Баасан багшийн Хууль зүйн шинжлэх ухааны салбарт оруулсан хувь нэмэр, үнэтэй хөдөлмөрийг нь үнэлэн төр засгаас Ардын хувьсгалын 60, 70, 80, 90, 2000, 2010, 2011 жилийн ойн медалиуд, 1985 онд Хууль зүйн албаны Тэргүүний ажилтан, 1990 онд Прокурорын тэргүүний ажилтан, 1997 онд Алтан гадас одон, 2000 онд Боловсролын тэргүүний ажилтан, 2007 онд Шүүхийн тэргүүний ажилтан, 2014 онд Монгол Улсын Гавьяат багш цолоор шагнагдсан байна.

Монгол Улсын Гавьяат багш, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Лэгцэгийн Баасан багшийн эрдэмлэг, хөдөлмөрч, ажилч хичээнгүй, шударга, зарчимч, эгэл даруу, хүнлэг, нөхөрсөг чанар нь бидний хамт олон, мянга мянган шавь нарын тань сэтгэл зүрхэнд үүрд хоногшин үлдэх болно.

Талийгаачийн гэр бүл, үр хүүхэд, төрөл төрөгсдөд гүн эмгэнэл илэрхийлье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/926